

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ,
ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ 2019 – 2022 жилүүд**

ӨЛГИЙ ХОТ
2019 он 07 сар 10 өдөр

Агуулга

Хөтөлбөрийн товчоо	
Өмнөх үг	
1. Одоогийн нөхцөл байдлын шинжилгээ, тэр дундаа эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн талаар хийгдэж байгаа ажлын дүгнэлт.....	
2. Хөтөлбөрийн зорилго ба зорилт	
2.1. Зорилго	
2.2. Зорилтууд	
3. Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, хэмнэх арга хэмжээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа	
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр	
5. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт мониторинг	
6. Хөтөлбөрийн хүрэх үр дүн	
7. Шалгуур үзүүлэлт	

Хавсралт № 1

ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧОО

Хөтөлбөрийн нэр	Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх дэд хөтөлбөр Баян-Өлгий аймаг
	- МУ-ын “Эрчим хүч хэмнэлтийн тухай” хууль
Хөтөлбөр боловсруулах үндэслэл	Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2018-2020) Монгол улсын Засгийн газрын “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2014 оны 147 дугаар тогтоол Эрчим хүчний сайдын 2018 оны 59 дүгээр тушаал “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” Улсын Их Хурлын 2015 оны 63 дугаар тогтоолоор баталсан ” Терезс эрчим хучний талаар баримтлах бодлого”
Хөтөлбөр захиалсан	Эрчим хүчний зохицуулах хороо
Хөтөлбөрийг удирдаж хийлгэсэн	АЗД-ын орлогч Ш.Хавыл
Хөтөлбөрийг боловсруулсан	АЗД-ын 2018 оны 09 дүгээр сарын 18-ын А/695 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Хөтөлбөрийн

Зорилго

Зорилтууд

- Орон нутгийн эрчим хүчний эх үүсвэрийг зохистой зарцуулах нөхцөлийг эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх замаар хангах.
- Үндсэн зорилтууд:
 - Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
 - Эрчим хүчийг тооцох системийг боловсронгуй болгох, тоолууржуулах;
 - Дулааны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх;
 - Цахилгааны эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэх;
 - Усан хангамжийн системийн үр ашгийг дээшлүүлэх;
 - Түлш хэмнэх, үр ашигтай зарцуулах арга хэмжээг хэрэгжүүлэх

Хөтөлбөрөөс хүлээж буй
үр дүн

- хөтөлбөр хэрэгжсэнээр: төсвийн байгууллагуудын эрчим хүчний зардал 3-5 хувь буурна. 2018 онтой харьцуулахад зардлыг жил бүр 5 % бууруулна;
Эрчим хүчний эх үүсвэрийн хэрэглээг 2018 онтой харьцуулахад 5 % бууруулна;
Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулснаар хөтөлбөр хэрэгжих хугацаанд 100.0-150.0 сая төгрөгийн хэмнэлт гаргана;
Төсвийн байгууллагуудад хэрэглэж байгаа түлш, шатах тослох материалыг харьцуулсан нөхцөлөөр 15-20 хувиар хэмнэнэ;

Өмнөх үг

Хөтөлбөрийг Монгол улсын “Эрчим хүч хэмнэлтийн тухай” хууль, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2018-2020), зэргийг үндэслэн Баян-Өлгий аймгийн засаг даргын тамгын газар, Аймгийн засаг даргын томилсон ажлын хэсэг, Цахилгаан сүлжээний газар, Эрчимбаян Өлгий ХК хамтран энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Эрчим хүчийг хэмнэж үр ашигтай хэрэглэх нь эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ард иргэдийн ая тухтай амьдрах орчинг сайжруулах, байгалийн нөхөн сэргээгдэхгүй нөөцийг ариг гамтай хэрэглэх дэлхий нийтийн чиг хандлагатай нийцэж байгаа юм.

Баян-Өлгий аймагт ашиглагдаж байгаа дулаан түгээх сүлжээний дийлэх нь 1980 онд хийгдсэн технологи, тоног төхөөрөмжийн хувьд хуучирч насжилт өндөр болсноос гадна дотоод хэрэгцээнд зарцуулж байгаа цахилгаан эрчим хүч дэлхийн дундажаас 1,5 дахин, цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдал 2 дахин их байгаа нь үр ашиг багатай тул хэмнэлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хөтөлбөрийг аймгийн эрчим хүчний 2015 оноос 2018 он хүртэлх судалгааг холбогдох байгууллагууд болон статистикийн тоо баримт материалыг үндэслэн боловсруулав.

1. Эрчим хүчний хэрэглээ, ба хэмнэлт үр ашгийн одоогийн нөхцөл ба дүн шинжилгээ

Цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон давуу талтай боловч аймгийн хэрэглэгчдийг цахилгааны эрчим хүчний хангамжийн эх үүсвэрээр ангилвал айл өрхийн төвлөрсөн систем 54 хувь, сэргээгдэх эрчим хүч 45 хувь цахилгаан хангамжид холбогдоогүй 1 хувь, дулааны эрчим хүчний хангамжийн эх үүсгэвэрийн хувьд төвлөрсөн дулаан хангамжинд 21 хувь, ердийн галлагаа 49 хувь, нам даралтын гар ажиллагаатай зуух 30 хувийг эзэлж байна.

Урьдчилсан тооцоогоор цахилгааны алдагдал 18 хувь, дулааны алдагдал 25 хувь байна.

Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа нийт гэрэлтүүлгийн хэрэгслийн 21 хувь нь улайсдаг чийдэн, 35 хувь нь туузан гэрэл, 44 хувь нь лед гэрэл байна.

Төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагууд эрчим хүч хэмнэлтийн талаар авсан тодорхой арга хэмжээ байхгүй, иргэд мэдлэг мэдээлэлгүй, эрчим хүчний үр ашигтай хэрэглээ төлөвшөөгүй, аймгийн хэмжээнд дулааны эрчим хүч хэмжих хэрэгсэл байхгүй байна.

Бодит байдалд дүгнэлт хийж үзэхэд “Эрчим хүчний хэмнэлтийн бодлого” гаргах асуудал зүй ёсоор тавигдаж байна. Бодлогыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр гарган биелэлтийг тооцож ажиллах, хүрсэн бодит түвшинг хадгалах, дээшлүүлэх нь зүйтэй байна.

Аймгийн эрчим хүчний хэрэглээний үр ашиггүй байдалд нөлөөлж байгаа голлох хүчин зүйлүүд нь :

- Байгууллагын ажилтнуудын эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэх сонирхол муу, хөшүүрэг байхгүй ;
- Түлш, шатахуун эрчим хүч, усны үр ашигтай хэрэглээг хянах систем байхгүй;
- Эрчим хүчний хэрэглээг тооцох тоолуурын систем хангалтгүй;
- Барилга байгууламж, үндсэн тоног төхөөрөмж, уурын зуух, инженерийн байгууламж, шугам сүлжээний насжилт, элэгдэл ихтэй;
- Хэрэглэгдэж байгаа материал эрчим хүчний үр ашиг багатай хэмнэлтгүй;
- Эрчим хүчний зарцуулалт ихтэй хуучин тоног төхөөрөмжтэй гэх мэт байна

Төсвийн байгууллагуудын эрчим хүчний эх үүсвэрийг хангагч байгууллага нь :

- Цахилгааны эрчим хүч: Цахилгаан Шугам Сүлжээний газар
- Дулааны эрчим хүч:
 - Өлгий сум - Эрчимбаян Өлгий ХК
 - Дэлүүн, Улаанхус сумууд – Жанат ХХК
 - Толбо, Цэнгэл сумууд – Агайын ХХК
 - Алтай сум – Нур Төрө ХХК
 - Алтанцөгц сум – ТММН ХХК
 - Баяннуур сум – Киели Жүйрик ХХК
 - Буянт сум – Ахбейл ХХК
 - Бугат сум – Ахниет ХХК
- Ус, уур СУАТ ХХК зэрэг юм.

2. Хөтөлбөрийн зорилго ба зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

Эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган уялдуулах, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, зардлыг бууруулах, үр ашигтай хэрэглэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн биелэлтийг хангаж, зорилгыг биелүүлэхийн тулд доор дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Эрчим хүчний хэмнэлтийн бодлогын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1 Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан үр ашигтай хэрэглээг дэмжсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.2.2 Эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаарх хичээлийг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийн агууллагад тусгах, олон нийтэд чиглэсэн мэдлэг, боловсролыг орон нутгийн радио телевизийн нэвтрүүлгээр түгээх замаар эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгож төлөвшүүлэх;

2.2.3 Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг, бусад тоног төхөөрөмжүүдийн эрчим хүчний хэмнэлттэй технологийг үе шаттайгаар нэвтрүүлэх;

2.2.4 Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, бусад төсөвт байгууллагын эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэлт гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх

2.2.5 Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, хэрэглэгчдийг хэрэгцээт дулаанаар ханган, тав тухтай орчинг бий болгох, хэмнэлттэй, үр дүнтэй хэрэглэхийн тулд дулааны хэмжих хэрэгслийг нэвтрүүлэх.

2.2.6 Эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологи бүхий техник хэрэгслийн хэрэглээг дэмжиж, улайсах гэрлийн хэрэглээг хориглох.

3. Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, хэмнэх арга хэмжээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан үр ашигтай хэрэглээг дэмжсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилтын хүрээнд:

1.1 Иргэдийн дадал заншилд өөрчлөлт оруулах (Цахилгаан төхөөрөмж, гэрэлтүүлэх хэрэгслийг ашиглахгүй үед унтрааж хэвших)

1.2. Хэмнэлтээс бий болсон хөрөнгийг тухайн байгууллагад хуримтлал үүсгэн хэмнэлтийн үйл ажиллагаанд зарцуулдаг байх

1.3. Жил тутам цахилгаан, дулааны зардлыг 3-аас доошгүй хувиар, шатахууны зардлыг 15-аас доошгүй хувиар тус тус бууруулах

2. Эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаарх хичээлийг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрийн агуулгад тусгах, олон нийтэд чиглэсэн мэдлэг, мэдээллийг түгээх замаар эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгож төлөвшүүлэх зорилтын хүрээнд:

2.1 Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр сургалт, сурталчилгааг өргөн хүрээнд зохион байгуулах

2.2 “Эрчим хүч хэмнэлт, зохистой хэрэглээ” сэдвээр ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-ийн хичээлийн хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэх

2.3 “Эрчим хүч хэмнэлт, зохистой хэрэглээ” сэдвээр ерөнхий боловсролын сургууль болон албан байгууллага, иргэдэд сургалт, семинар, сэдэвчилсэн уралдаан тэмцээн зохион байгуулах

3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг, бусад тоног төхөөрөмжүүдийн эрчим хүчний хэмнэлттэй технологийг үе шаттайгаар нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

3.1. Нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлгийг ЛЕД гэрлээр солих, цаашид байгалийн эх үүсвэр бүхий /нар, салхи г,м/ гэрэлтүүлэх хэрэгсэл ашиглах

3.2. ААН, байгууллага бүр гэрэлтүүлгийн стандартыг мөрдөж хэвших

3.3 Барилыг дотор ханыг цайвөр өнгөөр будах

4. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, бусад төсөвт байгууллагын эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэлт гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

4.1 Төрийн байгууллагуудын дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд эрчим хүч хэмнэлтийн талаар заалт оруулж биелэлтийг тооцох

4.2 Төрийн байгууллагуудын /Төсөвт болон орон нутгийн өмчит хуулийн этгээд/ үйл ажиллагаанд эрчим хүчний хэмнэлт бүхий техник хэрэгслийг худалдан авах

4.3 Аж ахуйн нэгж, байгууллага бүр эрчим хүч хэмнэх төлөвлөгөө боловсруулан, түүнийг хэрэгжилтийг хянах

4.4 Бүх аж ахуйн нэгж байгууллагууд хэмнэлтийн менежер томилон ажиллуулах

5. Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд;

5.1 Барилгын дулаан алдагдлыг бууруулах цогц арга хэмжээ авах /Судалгаанд тулгуурлан барилга бүрт шинжилгээ хийж дулаан алдагдлыг бууруулах/

5.2 Эрчим хүч /цахилгаан, дулаан/ бага зарцуулдаг техник хэрэгслийг ашиглах, хөрөнгө оруулалтыг үе шаттай шийдвэрлэх

5.3 Шинээр барихаар төлөвлөж буй барилгын зургийн даалгаварт эрчим хүч хэмнэлтийн асуудлыг тусгах

5.4 Цахилгаан, дулаан хэрэглэгч бүрийг тоолууржуулах /ухаалаг/ ажлыг үе шаттай шийдвэрлэх

6. Эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологи бүхий техник хэрэгслийн хэрэглээг дэмжиж, улайсах гэрлийн хэрэглээг хориглох.

6.1. Улайсах чийдэнг 2022 оноос эхлэн хэрэглээнд ашиглахгүй байх /айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэгт/

6.2. Хийн болон холимог шатахуун зарцуулдаг авто тээврийн хэрэгслийг ашиглах, нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэх

6.3 Эрчим хүчний хэмнэлтийн аудитыг бий болгох /Мэргэжилтэй боловсон хүчнээр хангах/

4. Хөтөлбрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр

4.1 . Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг 2019-2022 онд хэрэгжүүлэх

4.2. Эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараахь хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэх

4.2.1 Аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

4.2.2 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө

4.2.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжүүлэх хөрөнгө

4.2.4 Банкны зээлийн хөрөнгө

4.2.5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө

4.2.6. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө

4.2.7 Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт

4.2.8 Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө

4.2.9 Бусад

5. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, мониторинг

5.1 Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга, Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

5.2 Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдана.

5.3 Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран жил бүр хийж, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн болон аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаархи тайланг жил бүрийн 1-р улиралд багтаан Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлнэ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн бодлогод болон хэрэгжүүлэх ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно

6. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

6.1 . Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2022 онд дараахь үр дүнд хүрсэн байна.

6.1.1. Дулааны эрчим хучний хэрэглээг барилга байгууламж, орон сууцны эзэлхуун, талбайгаар албан байгууллага, айл өрхийн цахилгаан эрчим хучний хэрэглээг задгайгаар болон хуний тоогоор тооцож байгаа одоогийн тогтолцоог тоолууржуулах замаар бага багаар халсан байна

6.1.2. Иргэд олон нийт эрчим хучийг үр ашигтай зарцуулах, хэмнэх, зохистой хэрэглэх арга барил төлөвшсөн байна.

6.1.3. Эрчим хучний үр ашгийн талаар үйлчилгээ үзүүлэх, аудитын магдлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагатай болно.

6.1 В. Нуурсний хэрэглээг багасгаж, агаарын бохирдлыг 20-30 хувь буурсан байна.

6.1.4. Цахилгаан, дулаан дамжуулалт, тугээлтийн алдагдал 10-20 хувь буурсан байтна.

6.1.5. Цахилгаан, дулаан эрчим хуч уйлдворлэх жилийн зардлаас 100.0-150.0 сая тэгрөгийн хэмнэлт гарна.

7 Шалгуур үзүүлэлтүүд

Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, хэмнэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд, хяналтын үзүүлэлтүүдийг хавсралт №1 харуулав